

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ЗАЛУУ ОФИЦЕРУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА, ТҮҮНИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

SOCIAL SECURITY OF YOUNG OFFICERS IN THE COURT DECISION ENFORCEMENT AGENCY AND WAYS TO IMPROVE IT



Н.Байгалтуяа

*ДХИС-ийн 2024-7051 дүгээр дамжааны магистрант,
НШШГГ-ийн Сүхбаатар дүүргийн хэлтсийн дарга
бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах дэслэгч*

Товч агуулга: Орчин цаг үед аливаа байгууллагын хүний нөөцийн менежмент болон хүний нөөцийн бодлого нь материаллаг хүчин зүйлсээс илүүтэйгээр хүн төвтэй бодлого баримталж, тэдгээрийг хөгжүүлэх, урамшуулах, дэвшүүлэх нь “менежментийн бодлого, үйл ажиллагаа”-ны гол үндсэн чиглэл нь болж байна.

Төрийн болон хувийн хэвшил ялгаагүй байгууллагын хамгийн үнэт зүйлс болсон ажилтан, алба хаагчийн эдийн засаг, нийгмийн баталгааг хангах асуудал хурьцаар тавигдаж, шинжлэх ухааны бүхий л салбарт тэдгээрт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг шат дараатай авсаар байна.

Судлаачийн зүгээс Монгол улсын төрийн цэргийн ууган байгууллагын нэг болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ирээдүйн “залгамж, халаа” залуу офицеруудад тулгамдаж буй асуудал, нийгмийн баталгааг хангах асуудлыг судалгааны үндсэн дээр нээн илрүүлж, түүнийг зохих түвшинд дээшлүүлэх, шийдвэрлэх “арга, зам”-ыг эрэлхийлэхийг зорилоо.

Abstract: In the modern era, human resource management and HR policies in any organization are increasingly focused on people-centered approaches rather than material factors. Prioritizing the development, motivation, and promotion of personnel has become a core direction of management policy and practice.

Regardless of whether in the public or private sector, ensuring the economic and social security of employees—who are the most valuable asset of

any organization—has become an urgent matter. Across all branches of science, measures are being taken step by step to address the pressing issues faced by personnel.

From the researcher's perspective, this study aims to identify and explore the current challenges and issues related to the social security of young officers—the future successors—of one of Mongolia's oldest state military institutions, the General Executive Agency of Court Decisions. Based on research findings, the goal is to seek effective ways and means to enhance and resolve these issues appropriately.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих байгууллага, алба хаагч, эрх зүйн байдал, хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа, дээшлүүлэх арга зам

Key word: Court Decision Enforcement Agency, Penitentiary institution, Staff member, Legal status, Human resource policy, *Social security*

ҮНДСЭН ХЭСЭГ

Төр нийгмийн аюулгүй байдлыг хангах, тогтоосон хууль тогтоожмийн эсрэг гэмт явдлаас ард иргэд, тэдгээрийн эрх ашиг, сонирхолыг сахин хамгаалах нь бие даасан тусгаар улсын оршин тогтнох үндэс суурь, халдашгүй дархан байдлын хэмжүүр, гэмт үйлдлийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрүүгийн хариуцлага нь ард иргэдийг төрдөө итгэх итгэл, оршин тогтнохуйн дархлаа нь байдаг. (Д.Дамдинцэрэн, 2021, р. 11)

Энэ ч үүднээс “...төр түүний зохион байгуулалтын бүтцэд аюул, эрсдэл үүсгэгч гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон иргэн, аж ахуйн нэгжид эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх, ял оногдуулах нь...” манай улсын эрүүгийн ялын бодлогод анхаарал татсан асуудал болоод байна. (Э.Жамбалрагчаа, 2021, хууд. 52)

Эдүгээ цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тэртээ 1921 оны ардын хувьсгалын он жилүүдэд “Гяндан салаа” нэртэй байгуулагдсан цаг үеэс “төр нийгэм, ард иргэдийн аюулгүй байдлаас хамгаалах, гэмт этгээдийг төлөвшүүлэх, гэмт санаа, бодлогыг арилгах, хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх ажлын хүрээнд улс орны нийгэм, эдийн засагт өөрийн хувь нэмэрээ оруулах” эрхэм үүргээ нэр нөртэйгээр биелүүлж иржээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь мэргэжлийн олон төрлийн албадыг багтаасан, үйл ажиллагааны чиглэл тус бүр өөрийн өвөрмөц онцлог шинжтэй, 100 гаруй жилийн баялаг түүхтэй байгууллага бөгөөд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолын дагуу “эрүү, иргэн, захиргаа”-ний хэргийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн. (Н.Удвалцэцэг, 2021, хууд. 48)

Аливаа улс орон, байгууллагын хөгжлийн үйл явцын салшгүй нэг хэсэг, үндэс нь хууль эрх зүйн шинэтгэлийн асуудал байдаг бөгөөд үүгээр дамжин тухайн улс орны нийгмийн харилцаа боловсронгуй болж, цаашдын хөгжлийн чиг хандлага тодорхойлогдож байдаг. (В.В.Бабури, 2005, хууд. 7) Энэ ч утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч тэр дундаа “...залуу офицеруудын эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, тэднийг сурч боловсрох, дэвшин томилогдох нөхцөл бололцоогоор хангах, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх...” цаг үеийн шаардлага байна гэж судлаачийн зүгээс үзсэн бөгөөд “...шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын нийгмийн баталгаа, түүнийг дээшлүүлэх арга зам...” ерөнхий сэдвийг дараах 3 асуудлын хүрээнд тоймлон авч үзсэн. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй нийтлэг хүндрэл бэрхшээл;
2. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын залуу офицеруудын цалин хангамжид хийсэн дүн, шинжилгээ,
3. ОХУ болон гадаадын бусад улс орнуудын хорих байгууллагад ажиллаж буй алба хаагчдын сарын цалин хангамж бусад нэмэгдлийн харьцуулсан судалгаа.

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй нийтлэг хүндрэл бэрхшээл


Судлаачийн зүгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй асуудлын нээн илрүүлэх үүднээс судалгааны “санал, асуулга”-ын аргыг ашиглан дараах судалгаануудыг болосвруулж нэгтгэсэн бөгөөд эрхэм эрдэмтэн, судлаач, уншигч Та бүхэнд үр дүнг тойм хэлбэрээр танилцуулья.

2024 оны эхний хагас жилийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд “...эрэгтэй – 9.3%, эмэгтэй – 5.4 %, нийт залуу офицерууд байгууллагын албан хаагчийн 15.0% орчим хувийг эзэлж байгаа нь...” тэдний байгууллагын алба хаагчийн дунд эзлэх байр суурь, дуу

хоолой бусад насны офицер, ахлагч нараас харьцангуй бага байгааг харуулахаас гадна “..энэ насны залуу алба хаагчдын ажлаас өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх асуудал их байгаатай шууд холбоотой”.

Байгууллагын хэмжээнд чөлөөлөгдсөн алба хаагчдын насны байдлыг авч үзвэл 26-35 насны дээд боловсролтой залуу офицерууд 60 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд өмнө нь эрхэлж байсан албан тушаалын хувьд “...ээлжийн харуул хамгаалалтын алба хаагч, эмнэлгийн ажилтан, шийдвэр гүйцэтгэгч...” нар хамгийн олноор ажлаас чөлөөлөгдсөн байна. (Б.Алтангэрэл, 2020, хуудсд. 69-70)

Хүснэгт. 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын тоон судалгаа




Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид голчлон “...ямар шалтгааны улмаас ажлаас гардаг гэж үзэж байна вэ...” гэсэн асуултад цалин хангамж бага – 20.7%, ажлын ачаалал их – 19.3%, гадаадад ажиллах – 10.6%, орон нутагт ажиллах боломжгүй – 9.7%, ажлын байрны дарамт их – 14.1%, мэдлэг, боловсролоо дээшлүүлэх – 5.6% гэсэн сонголтуудыг хийсэн байна.

Байгууллагын ажилд нэн тулгамдсан асуудлыг нэгдүгээрт, цалин хөлс бага- 82,3%, хоёрдугаарт амьдрах орон нууц байхгүй-50,8%, гуравдугаарт, хамт олны уур амьсгал – 34,7%, дөрөвдүгээрт, удирдах ажилтны арга барил-32,8%, тавдугаарт, дэвшин томилогдох болон гэр бүлийн гишүүд хамт нэг байгууллагад ажиллах боломж хомс – 13,7% гэсэн байдлаар эрэмбэлэж сонгосон байна.

Хүснэгт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудад тулгамдсан асуудлууд тоон үзүүлэлт

Таны ажилд тулгамдсан нэн тэргүүний 3 асуудлыг тэмдэглэнэ үү.

124 responses




Амьдарч буй орон сууцны хувьд түрээсийн орон сууцад амьдарч байгаа – 33.1%, хувийн орон сууцад амьдарч байгаа – 29.1%, албаны орон сууцад амьдарч байгаа – 20.2%, хашаа байшинд амьдарч байгаа – 10.1% эндээс бид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын гуравны нэгээс дээш хувь нь түрээсийн орон сууцанд амьдардаг, амьдрах орон байраар хангагдаагүй, ажлын орчин нөхцөл хүндрэлтэй гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 2. Залуу офицеруудын амьдарч буй орон байрны үзүүлэлт

Таны амьдарч буй орон байр?

124 responses




Орон сууц худалдаж авсан хэлбэрийн хувьд бэлэн мөнгөөр худалдаж авсан – 16.9%, ипотекийн зээлд хамрагдсан – 54.8%, бэлэглэл, өв залгамжлалаар худалдаж авсан – 28.2% тус тус эзэлж байгаагаас залуу офицеруудын гуравны нэг хүрэхгүй хувь нь хувьдаа орон сууцтай боловч 60 % орчим хувь нь ипотекийн зээлд хамрагдаж орон сууц худалдаж авсан

байна. Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй 21-35 насны залуу офицеруудын 95 хувь нь хэрэглээний болон цалингийн 10-25 сая төгрөг хүртэл зээлтэй байна.

Хоёр. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын залуу офицеруудын цалин хангамжид хийсэн дүн, шинжилгээ,

Илтгэлийн энэ дугаарт Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хил хамгаалах, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагын алба хаагчдын нэг сарын үндсэн цалингийн хэмжээ, шатлал, бусад нэмэгдлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай харьцуулж авч үзье.

Хүснэгт 4. Төрийн тусгай алба хаагчдын 1 сарын үндсэн цалин, бусад нэмэгдлийн харьцуулалт



Эндээс үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын сард авч буй үндсэн цалин бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагаас харьцангуй бага байна. Тухайлбал, Хил хамгаалах байгууллагын онцгой албаны нэмэгдэл 50 %, Онцгой байдлын байгууллага – 30 %, Цагдаагийн байгууллага – 25 %, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага – 15 % тогтоосноос гадна “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицерийн цалингийн шатлал “ТТ-9” буюу бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын ахлагчийн шатлалтай ижил...” түвшинд байна.

Үүнээс гадна үндсэн цалингийн шатлалын хэмжээ Хил хамгаалах, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг шатлалаар бага, бусад тусгайлсан чиг үүрэг бүхий

байгууллагуудын сард авч буй “мэргэжлийн зэргийн нэмэгдэл”-ийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тогтоож өгөөгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын сард авч буй цалингийн хэмжээ Цагдаагийн байгууллагын алба хаагчаас 334.500 ₮, Онцгой байдлын байгууллагаас 412 500 ₮, Хил хамгаалах байгууллагаас 601.500 төгрөгөөр тус тус бага байна.

Ээлжийн амралтын нэмэгдэл хоногийн тухайд Цагдаагийн байгууллага нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан нэмэгдэл хоногоос гадна Цагдаагийн албаны тухай хуулийн 90 дүгээр зүйлд зааснаар “...Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт...” авахаар заасан нь алба хаагчийн ажлын нөхцлөөс шалтгаалан “...ээлжийн амралтын хоногийг нэмэгдлээр сунгаж өгсөн, алба хаагчаа бодсон, хуулийн шинэлэг зохицуулалт...” болжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухайд ШШГЕГ-ын даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн тушаалаар батлагдсан “ШШГБ-ын хөдөлмөрийн дотоод журам”-д заасан “...алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт авахаар зохицуулсан...” нь төсөөтэй чиг үүрэг хэрэгжүүлдэг, ажлын орчин нөхцөлийн хувьд харьцангуй хүнд манай байгууллагын хувьд Цагдаагийн байгууллагад жишигт хүрэхгүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор “алба хаагчийн ажил, амралтын нэмэгдэл хоногийг шинэчлэн боловсруулах” шаардлага бий болсныг илтгэн харуулж байна.

Алба хаагчдын хоол, хүнсний хангамжийн хувьд Засгийн газрын 2018 оны 261 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний хангалтын хэмжээ”-ээр бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүнсний хангамжаас 2 дахин бага байна.

Гурав. ОХУ болон гадаадын бусад улс орнуудын хорих байгууллагад ажиллаж буй алба хаагчдын сарын цалин хангамж бусад нэмэгдлийн харьцуулсан судалгаа.

Оросын Хорих Улсын Ял эдлүүлэх байгууллагын хувьд алба хаагчийн сарын цалингийн хэмжээг “...үндсэн цалин, ажилласан жил, цолны нэмэгдэл болон бусад нэмэгдлүүд буюу тухайн хорих ангийн ял эдлүүлэх дэглэм, хорих ангийн байрлаж буй байршил...” зэргийг харгалзан тогтоодог байна. (Zarabativaem, 2023)

Жишээлбэл, хорих ангийн жижүүрийн дарга сард үндсэн цалин 32 000 рубль, онцгой албаны нэмэгдэл 19 000 рубль, албан тушаал цолны нэмэгдэл 13 000 рубль, төрийн албаны нэмэгдэл 5000 рубль, нийт 69000 рубль буюу 3 сая төгрөгийн цалин авдаг байна.

Түүнчлэн залуу алба хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс орон сууцны хөнгөлөлттэй хөтөлбөр буюу 4-6 хувийн зээлд хамруулсан, бага насны хүүхдүүдийн цэцэрлэгийг байгууллагын байрлал орчим үнэ төлбөргүй шийдсэн, алба хаагчийн хоол, унааны зардлаас чөлөөлсөн зэрэг шинэлэг шийдлүүдийг авч хэрэгжүүлсэн үр дүнтэй болсон талаар Холбооны ял эдлүүлэх газрын цахим хуудаст мэдээлжээ. (хаяг, 2023)

Европын бусад орнуудын хувьд Хорих байгууллагын алба хаагчийн цалинг дараах байдлаар тогтоосон байна. Тухайлбал, Польш улсад \$900 буюу 3,9 сая төгрөг, Грек улсад 6.9 сая, Францид \$3600 буюу 12,9 сая, Англи улсад \$3700 буюу 13 сая орчим байхаар тус тус тогтоосон байна.

Эндээс үзэхэд Оросын Холбооны улс болон Польш улсын ял эдлүүлэх байгууллагын алба хаагчийн сарын цалин Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цалингаас нэг дахин илүү, Барууны өндөр хөгжилтэй улс орнуудын залуу офицеруудын цалин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сарын цалингаас харьцангуй буюу 2-3 дахин их байгаа нь алба хаагчийн нийгмийн асуудалд түлхүү анхаарч байгаатай шууд холбоотой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Бидний зорилт болгон авч үзсэн судалгааны нэгдсэн дүнгээс харахад “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 21-35 насны залуу офицеруудын цалин, хангамж бага, бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын төвшинд хүрдэггүй, амьдрах орон сууцаар хангагдаагүй, түрээсийн орон сууцанд амьдардаг, байр орон сууц худалдаж авсан хэдий ч ипотекийн зээлд хамрагдсан, цалингийн болон хэрэглээний асар өндөр зээлтэй тул сард авч буй цалин ар гэр, үр хүүхдээ тэжээхэд хүрэлцдэггүй...”

зэргээс “...Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын залуу офицеруудын нийгмийн баталгаа хангагдахгүй байгаа...” гэж дүгнэж болохоор байна.

Залуу офицеруудын өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон гадаад улсад ажиллахаар явсан тоо нэмэгдсэн нь “...алба хаагчдын цалин хангамж бага, ажлын ачаалал болон ажлын байрны дарамт шахалт их, орон нутагт гэр бүлээрээ ажиллаж амьдрах боломжгүй, шинээр томилогдсон алба хаагчийг хүлээн авах хамт олны уур амьсгал муу, ажлын орчин нөхцөл хүндрэлтэй...” зэрэг тулгамдсан асуудлуудтай шууд уялдаа холбоотой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Түүнчлэн залуу офицеруудын үзэж байгаагаар байгууллагад нэн тулгамдсан асуудалд цалин хангамжаас гадна хамт олны уур амьсгал, удирдах ажилтны арга барил, шударга зарчмаар дэвшин томилогдох боломж хомс зэргийг дурдсан нь алба хаагчийн нийгмийн баталгаа сайжруулах оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн хамт “...удирдах албан тушаалтны зөв арга барилыг төлөвшүүлэх, залуу офицеруудад шударга зарчмаар дэвшин томилогдох бололцоог нээж өгөх, байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй төвшинд хүргэх, алба хаагчийн албандаа итгэх итгэл, үнэмшил, албаны бахархалыг нэмэгдүүлэх замаар хамт олны уур амьсгалыг сайжруулах шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх...” цаг үеийн шаардлага бий болсон болохыг бидний залуу үе Та бүгдэд сануулж байна.

Судлаачийн зүгээс “шийдвэрлэх арга зам”-ыг дараах байдлаар тодорхойлж байна.

Үүнд:

Нэгдүгээрт: Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/235 дугаар тушаалын хавсралтаар шинэчлэн батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл”-д алба хаагчдын цалингийн шатлалыг бууруулсныг буцаан нэмэгдүүлэх, бусад төрийн тусгай байгууллагуудын шатлалтай нэг түвшинд хүргэх;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын онцгой нэмэгдлийг хэрэгжүүлж буй чиг үүргээр буюу (иргэний болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа) зэргийг жишилгүйгээр харилцан ялгамжгүй

тооцоолж, бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай нэг төвшинд хүргэж, 20-30 хувиар нэмэгдүүлэх,

3. Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал 2021 оны 12 дугаар сарын 10 өдөр "Хууль зүй дотоод хэргийн салбарын алба хаагчдад орон сууцны дэмжлэг, тусламж үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нийтлэг журам"-ыг шинэчлэх, залуу офицер, ахлагч нарт хөнгөлөлттэй хэлбэрээр, урьдчилгаа төлбөргүйгээр орон сууцтай болох боломжийг бүрдүүлэх;

4. Залуу офицеруудын цалингийн болон хэрэглээний зээлийг нэг удаад тэглэх, арилжааны банкуудтай хамтарч ипотекийн болон хэрэглээний зээлийн хүүг бууруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;

5. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 261 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний хангалтын хэмжээ” бусад тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагаас 2 дахин бага байгааг нэмэгдүүлж, ижил төвшинд хүргэх.

Хоёрдугаарт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Байгууллагын алба хаагчдад орон сууц олгох хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг шинэчлэх, орон сууцны урьдчилгаа төлбөрийг бууруулах, төлөлтийг уян хатан нөхцөлтэйгээр шийдвэрлэх, орон сууцанд хамрагдах хүсэлт гаргасан дарааллыг нээлттэй, ил тод байршуулж, хуваарилалтыг шударга хийх;

2. Шинээр томилогдсон алба хаагчдад тухайн хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх асуудлыг шат дараатай арга хэмжээг зохион байгуулах, байгууллагын хэмжээнд алба хаагчдын орон сууц хөтөлбөрийг авч хэрэгжүүлэх;

3. Ирж буй 2025 оныг “байгууллагын алба хаагчдын албандаа итгэх итгэл үнэмшил, албаны бахархалыг сэргээх, залуу алба хаагчдын манлайллын жил болгон зарлах” жил болгон зарлах, залуу болон ахмад алба хаагчид гавьяаны амралтандаа гарсан бэлтгэл офицеруудын дунд “миний алба, миний бахарал” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулах,

4. Байгууллагын хэмжээнд шатлан дэвших буюу шударга зарчмаар дэвшин ажиллах бодлогын баримт бичгийг боловсруулж, биелэлтийг хангуулж, удирдлагын зүгээс зөв хандлагыг төлөвшүүлж, шинэ залуу офицер, алба хаагчдын ажилдаа хандах дур сонирхолыг нэмэгдүүлэх,

нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээг шат дараатай зохион байгуулах.

Эх сурвалж

1. Zarabativaem, A. ё. (2023, 8 07). Оросын Холбооны Улсын Хорих байгууллагын алба хаагчдын сарын дундаж цалин, бусад нэмэгдлийн харьцуулалт. Retrieved from zarabativaem.com: <https://zarabativaem.com/zarplata-v-fsin-v-raznyx-gorodax-rossii/>
2. Б.Алтангэрэл. (2020). “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт” судалгааны тайлан. Улаанбаатар.
3. В.В.Бабулин. (2005). Монография: Система уголовного права. Омская Академия МВД России.
4. Д.Дамдинцэрэн. (2021). Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах гарын эмхэтгэл. Улаанбаатар.
5. Н.Удвалцэцэг. (2021). "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй алба хаагчийн эрх зүйн байдалд тулгамдаж буй асуудал", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар.
6. О. Х. (2023, 8 07). Федеральная служба исполнения наказаний (ФСИН России). Retrieved from Правительство России: <http://government.ru/department/100/events/>
7. Э.Жамбалрагчаа. (2021). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Сүлд инфо" сэтгүүл. Улаанбаатар.

“Урсан өнгөрөх цаг хугацаа залуусын мөрөөр тамгалагдна, бид айсуу цагийн эзэд”